



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Нүүдэлчин малчид, Уул уурхайн компани, Орон нутгийн засаг захиргаа хоорондоо бүрэн тохиролцоонд хүрснээр ЭЗХНЗОГ Оюу Толгой уурхайтай холбоотой Зуучлан чиглүүлэх ажиллагааг дуусгавар болгов

2019 оны 3 сарын 18 – Дэлхийн Банкны Группийн Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) нүүдэлчин малчид, уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргааны хооронд гомдол барагдуулахаар байгуулсан гэрээний хэрэгжилтийн явцад мониторинг хийсний дараа Монгол улсын Оюу Толгойн алт, зэсний уурхайтай холбоотой маргаан шийдвэрлэх ажиллагаагаа дуусгавар болголоо. Уламжлалт соёл, амьжиргаанд уул уурхай сөрөг нөлөөлөл учруулж буй талаар нутгийн малчин иргэдийн гаргасан хоёр гомдлыг шийдвэрлэхийн тулд ЭЗХНЗОГ 2012 оноос холбогдох талуудтай хамтран ажиллаж ирсэн билээ.

Оюу Толгой төсөл нь Монгол улсын Өмнийн говийн бүс нутагт алт, зэсний уурхай байгуулах олон тэрбум долларын хөрөнгө оруулалт юм. Оюу Толгойг Монгол улсын Засгийн газар (34 хувь) болон Туркойз Хилл Ресурс (66 хувь, үүний 51 хувийг нь Рио Тинто өмчилдөг) хамтран өмчилдөг. Дэлхийн Банкны Группийн гишүүд болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлаг (ОТХОБА) энэ төсөлд дэмжлэг үзүүлсэн.

Хоёр хэсэг малчид орон нутгийн, үндэсний мөн олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын туслалцаатайгаар (Говийн Газар Шороо, ОТ Хяналт, Аккаунтэбилити Консул зэрэг) 2012 оны 10 сар, 2013 оны 2 сард тус тус ЭЗХНЗОГ-г гомдол гаргаж, уурхайн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын хөтөлбөр хангалтгүй явагдсан, уурхайн улмаас Ундай голын гольдролын өөрчилснөөр орон нутгийн усны нөөцийг шавхаж, бэлчээрийг доройтуулан, нутгийн иргэдийн тахилга шүтлэгт аюул учирч буй талаар асуудал тавьсан болно.

Гомдлын дагуу ЭЗХНЗОГ-аас явуулсан маргаан шийдвэрлэх зуучлалын ажиллагааны үр дүнд нутгийн иргэд, компани, орон нутгийн засаг захиргааны хооронд ус, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, голын гольдролын өөрчлөлтийн талаарх гомдлуудыг шийдвэрлэх гэрээнүүдийг байгуулсан. Зуучлалын үйл явцын үеэр талууд нутгийн малчид, Оюу Толгой компани, Ханбогд сумын засаг захиргааны тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн “Гурван Талт Зөвлөл”-ийг үндэслэн байгуулав. Гурван Талт Зөвлөл нь гомдолд дурдсан малчид, бэлчээр, устай холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх, мэдээлэл солилцох, зөвлөмж гаргах, гэрээнүүдийн хэрэгжилтийн хангах, холбогдох байгууллагуудад асуудлыг уламжлах үүрэгтэй. Гурван Талт Зөвлөлийн хамтарсан мэдэгдлүүд, гарын үсэг зурсан гэрээнүүдийг ЭЗХНЗОГ-ын цахим хуудаснаас үзэж болно. ЭЗХНЗОГ гомдлуудыг хаасны дараа Гурван Талт Зөвлөл нь зуучлалын явцад байгуулсан гэрээнүүдийг хэрэгжүүлэх ажлаа хамтдаа үргэлжлүүлэн, орон нутгийн бодлого боловсруулалт, хамтын ажиллагааны бусад төслүүдэд зөвлөгөө өгч байх болно.

ЭЗХНЗОГ ба Гурван Талт Зөвлөл гомдлыг хаах албан ёсны уулзалтыг 2019 оны 3 сарын 22-нд Монгол улсын Ханбогд суманд, туршлага солилцох арга хэмжээг 2019 оны 3 сарын 25-нд Улаанбаатар хотноо зохион байгуулна. Туршлага солилцох бага хуралд хувийн хэвшил, иргэний нийгмийн болон засгийн газрын байгууллагууд, олон улсын донор, хөгжлийн байгууллагууд оролцож Монгол улсад ЭЗХНЗОГ-ын зуучлан чиглүүлсэн маргааныг хамтдаа шийдвэрлэх, баримт хамтран олж тогтоох үйл явцын бодит туршлага, үр өгөөж, сорилтуудын талаар харилцан ярилцаж, санал бодлоо хуваалцах боломжийг оролцогчдод олгох зорилготой.

Холбогдох баримт бичгүүдийг ЭЗХНЗОГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.cao-ombudsman.org.

Холбоо барих, Вашингтон ДС: Эмили Хорган ehorgan@worldbankgroup.org Tel: +1 202-473-8353

ЭЗХНЗОГ-ын тухай: ЭЗХНЗОГ нь Дэлхийн Банкны Группийн гишүүд болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагийн (ОТХОБА) Хариуцлагын Хараат Бус Механизм юм. ЭЗХНЗОГ нь ОУСК, ОТХОБА-ийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн гомдлыг шударгаар, бодитой, үр дүнтэй байдлаар шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд байгаль орчин, нийгэмд ирэх үр нөлөөг газар дээр нь сайжруулах зорилготой. ЭЗХНЗОГ нь Дэлхийн Банкны Группийн Ерөнхийлөгчид шууд тайлагнадаг. ЭЗХНЗОГ-ын нийцлийн хяналт нь ОУСК, ОТХОБА-ийн гүйцэтгэлд анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд ОУСК, ОТХОБА-ийн үйлчлүүлэгчид болон тэдний бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй.